

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Үндэсний Аудитын газар
2021 он**

АГУУЛГА

| | |
|--|-------|
| Агуулга | 1 |
| Товчилсон үгийн жагсаалт | 2 |
| Аудитын нэр | 3 |
| Аудитын код | 3 |
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | 3 |
| Аудитын зорилт | 3 |
| Аудитын хамрах хүрээ | 3 |
| Үндсэн мэдээлэл | 4 |
| Эрсдэлийн үнэлгээ | 4 |
| Аудитын арга зүй | 4 |
| Аудит хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт | 5 |
| Аудитын гүйцэтгэх хугацаа | 5 |
| Аудит хийх багийн бүрэлдэхүүн | 5 |
| Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц | 5-6 |
| Хавсралт ¹ №1 Эрсдэлийн үнэлгээ | 7 |
| Хавсралт №2 Асуудлын шинжилгээ | 8 |
| Хавсралт №3 Аудитын арга зүй | 9-13 |
| Хавсралт №4 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт | 14 |
| Хавсралт №5 Аудитын хөтөлбөр | 15-16 |
| Хавсралт №6 Аудитын төсвийн тооцоо | 17 |

¹ Хавсралтуудыг зөвхөн Төрийн аудитын байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглана.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АНГ | Аудитын Нэгдүгээр газар |
| АНТАГ | Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| НА | Нийцлийн аудит |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ШДНЦХ | Шилэн дансны нэгдсэн цахим хуудас |
| ШТА | Шууд тайллагнах ажил |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ЗАНДАНБАТ

Зандаан

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2. Аудитын код: АНГ-2021/125/-ШТА-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтыг үндэслэн, МҮЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

4. Аудитын зорилт:

Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийт үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа ХК, ХХК-уудын Шилэн дансны үйл ажиллагаанд аудит хийж, байнгын бодит цагийн хяналтыг хэрэгжүүлэн, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дүнг улсын хэмжээнд нэгтгэх;
- Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй² төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах байгууллагуудын 2020-2021 оны худалдан авалтын үйл ажиллагаанд байнгын бодит цаг /real time/-ийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шилэн дансны эрсдэл бүхий мэдээллийн дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, аудитад иргэд, олон нийтийн оролцоог хангуулах.

² Санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргасан, үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн /түүвэрт хамруулсан/, ХАК-аар гэрээний үндсэн дээр аудит хийлгэснээс бусад компани хамаарна.

5. Аудитын хамрах хүрээ:

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй³ төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн үйл ажиллагааг хамруулан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дүнг улсын хэмжээнд нэгтгэн гаргана.

Энэ удаагийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны хуулийн хэрэгжилтийн байдлыг хязгаарлана.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах байгууллагуудын 2020-2021 оны худалдан авалтын үйл ажиллагаанд эрсдэлд суурilan байнгын, бодит цаг /real time/-ийн хяналтыг жилийн туршид хэрэгжүүлнэ.

Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шилэн дансны эрсдэл бүхий мэдээллийн дагуу тухай бүр тодорхой арга хэмжээ авч, иргэд, олон нийтийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Төрийн аудитын байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн 2020 оны хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитаар хослуулан шалгаж, дүнг улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хамт УИХ-д хүргүүлж, олон нийтэд мэдээлхээр ажиллаж байна.

Төсвийн байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Шилэн дансанд байнгын хяналтыг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий аудиторт өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сард Шилэн дансны хяналтын хэлтэс байгуулсан.

Үүний хүрээнд Шилэн дансны тухай хуульд заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу Төрийн аудитын байгууллагаас холбогдох data мэдээлэлд үндэслэн, шилэн дансны хяналтад иргэдийн оролцоог хангуйж, байнгын хяналт тавих бодит цагийн аудитыг гүйцэтгэх тогтолцоог бий болгохоор ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016-2020 онуудад хийсэн нийцлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын томьёоллыг боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлэхээр Ажлын хэсэг томилон ажиллуулж байна.

Мөн Сангийн яаманд байгуулагдсан Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг шинэчлэх, нэгдсэн цахим хуудсыг хөгжүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын

³ Санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргасан, үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн /түүвэрт хамруулсан/, ХАК-аар гэрээний үндсэн дээр аудит хийлгэснээс бусад компани хамаарна.

⁴ 3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

⁵ 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

хэсгийн бүрэлдэхүүнд Үндэсний аудитын газрын холбогдох албан хаагчдыг оролцуулж, хамтран ажиллах ажлыг эхлүүлээд байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг "ДУНД" гэж үнэлсэн.

8. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 4 : 2020 Төрийн аудит. Санхүүгийн аудитын тулгуур зарчим, MNS 6817 - 5 : 2020 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 7 : 2020 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандарт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг баримтална. Хуулийг үйлчлэлд хамаарах байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзарт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл болон Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тооцоходо хуульд заасан хугацааг баримталсан эсэх, холбогдох мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулсан эсэхийг шинээр боловсруулсан "Шилэн дансны нэгтгэлийн систем"-ийг ашиглан үнэлж, хувиар тооцож, илэрхийлнэ.

Шилэн дансны мэдээлэлд байнгын, бодит цагийн хяналтыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоог хангуулан эрсдэлтэй асуудлыг тухай бүрд аудит хийх чиг үүрэг бүхий газрууд болон АНТАГ-т шилжүүлж аудитад хамруулна.

Мөн аудитын явц, үр дүнг олон нийтэд мэдээлэх, иргэд, олон нийтээс мэдээлэл, санал авах үйл ажиллагааг Харилцаа, хамтын ажиллагааны газартай хамтран хэрэгжүүлнэ.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

10. Гүйцэтгэх хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 05 дугаар сарын 10-ны өдрөөс тус тус эхлүүлнэ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2020 оны дүнг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэгтгэн, Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн хамт МУЕА-ын тушаалаар баталгаажуулан, УИХ-д хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

Аудитын хоёрдугаар газар, Аудитын дөрөвдүгээр газар болон АНТАГ-ууд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад хамруулсан байгууллагуудын шилэн дансыг шалгасан дүнг Шилэн дансны нэгтгэлийн системд 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн оруулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах байгууллагуудын 2020-2021 оны худалдан авалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шилэн дансны эрсдэл бүхий мэдээллийн дагуу бодит цагийн хяналтыг жилийн туршид хэрэгжүүлж, үр дүнг холбогдох эрх бүхий этгээд болон олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

11. Багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Аудитын нэгдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан хянан удирдаж, Шилэн дансны хяналтын хэлтсийн дарга Д.Огтонбаяр аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Анхбаатар, аудитор Ц.Цэрэннамжил, Ц.Батсүх, А.Баясгалан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын явц, үр дүнг олон нийтэд мэдээлэх, иргэд, олон нийтийн оролцоог хангулан ажиллана.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

A. Боловсон хүчин:

- АНГ болон ХХАГ-аас: 7 хүн 211 өдөр, нийт 1477 хүн/өдөр;
- Аудит хийх чиг үүрэг бүхий газрууд болон АНТАГ: 66 хүн 105 өдөр, нийт 6930 хүн/өдөр.

Б. Санхүүгийн нөөц:

- Байгууллагын батлагдсан төсөвт тусгагдсан цалингийн болон бусад зардал.

В. Техник хэрэгсэл: Автомашин, зөөврийн компьютер болон бусад тоног төхөөрөмж;

Г. Бусад /дүн шинжилгээ хийх программ хангамж гэх мэт/

ТАНИЛЦСАН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б. Н. М.

Ц.НАРАНЧИМЭГ

ХЯНАСАН:

АУДИТЫН НЭГДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С. Наранчимэг

Ц.ЭНХЖАВХЛАН

ШИЛЭН ДАНСНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН *Д. Отгонбаяр*
ДАРГА

Д.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б. Анхбаатар

Б.АНХБААТАР

АУДИТОР

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

Д. Батсуух

Ц.БАТСҮХ

А. Баясгалан

А.БАЯСГАЛАН